



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2023/27/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2023 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр	
	Утас: 70483413	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг	
	Утас: 70484055	Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
	Ахлах аудитор :	Б.Цэвэлмаа
	Утас: 99026016	Цахим хаяг: tsevelmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-12
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ГЭР БҮЛ,
ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА
Б.АЛТАЙБААТАР ТАНАА

2023.02.24

№

46

танай

-ны №

-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын онцолсон хэсэг

Говь-Алтай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын тогтмол зардлын санхүүжилтийг орон нутгийн төсвөөс олгодог байсан бол 100% улсын төсвөөс санхүүждэг байгууллага болсон байна.

Тайлант онд 21.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч, 11.3 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь хүүхэд багачуудад Монгол ес заншил, нүүдэлчин ахуй, өв уламжлалаа өвлүүлэх зорилготой хүүхэд хөгжлийн “Засагт ханы хот айл-гэр зуслан” хөтөлбөрт 18 сум, 2 тосгоны 636 хүүхдийг хамруулжээ. “Өрх бүрт соёлыг түгээе” угийн бичиг хөтлөх сургалтыг аймгийн хэмжээнд зохион байгуулж 135 сургагч багш бэлтгэн 2334 хүнийг хамруулсан байна.

0702000056

Тус байгууллага нь тайлант онд 4 зорилтын хүрээнд 75 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, 97.2 хувийн биелэлттэй гэж дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

мянган төгрөгөөр

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	69,474.6	66,247.8
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,120,505.0	2,996,174.6
	Нийт хөрөнгийн дүн	3,189,979.6	3,062,422.3
	Нийт өр төлбөрийн дүн	9,643.1	25,094.8
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,180,336.5	3,037,327.6
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,189,979.6	3,062,422.3
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	933,058.5	873,260.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	905,360.0	976,269.4
	Үйл ажиллагааны үр дүн	27,698.5	- 103,009.0
	Үйл ажиллагааны бус үр дүн		- 40,000.0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	27,698.5	- 143,009.0
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,152,638.0	3,180,336.5
	Тайлант оны үр дүн	27,698.5	- 143,009.0
	Эцсийн үлдэгдэл	3,180,336.5	3,037,327.6
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	810,661.0	817,343.0
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	779,402.1	795,835.0
	Үйл ажиллагааны ЦМГ	31,258.9	21,508.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	- 31,258.9	- 21,508.0
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	- 0	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	712,271.7	669,064.8
	Урсгал зардал	712,271.7	669,064.8
	Хөрөнгийн зардал	-	
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	712,271.7	669,064.8
	Улсын төсвөөс санхүүжих	419,531.2	669,064.8
	Орон нутгийн төсвөөс	292,740.5	

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 156.0 сая төгрөгийн алдаа¹, нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг зөрчсөн 103.5 сая төгрөгийн гүйлгээг аудитын явцад гүйлгээг нөхөн шивүүлж, зөрчлийг арилгасан.

Үүнд:

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой: Нийт 2.2 сая төгрөгийн авлагыг дутуу тайлагнасан, газрыг бүртгэхдээ 8.8 сая төгрөгийг өмнөх үеийн үр дүн дансанд бүртгэсэн, байгууллагад үнэ төлбөргүй ирсэн 4.7 сая төгрөгийн хөрөнгийг дутуу бүртгэсэн. Санхүүгийн үр дүнгийн тайланд зардлын эдийн засгийн ангиллыг 13.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой: Ажилчдад 0.4 сая төгрөгийн цалин илүү олгосон, хувь хүний орлогын албан татварын тайланд 5.3 сая төгрөгийн цалин, хөдөлмөрийн хөлсийг дутуу тайлагнасан, төвлөрүүлэх шилжүүлгийн 17.8 сая төгрөгийн дансны ангиллыг зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах," гэж заасныг зөрчсөн.

Хууль тогтоомжтой холбоотой: Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 103.5 сая төгрөгийн гүйлгээг системд нөхөн шивүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 17.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 1.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 15.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 7 заалт албан шаардлага, 1 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

- ✓ Цалингийн урьдчилгаа 0.75 сая төгрөгийг дутуу суутгасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Хүүхэд харах үйлчилгээний хөлсийг 0.3 сая төгрөгөөр илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Томилолтын удирдамж, хөтөлбөргүй албан томилолтоор ажиллаж 0.5 сая төгрөгийн тээвэр шатахууны зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.1-т "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Албан шаардлага

- ✓ Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд ажилчдын 2.0 сая төгрөгийн цалинг дутуу, 0.7 сая төгрөгийн цалинг илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 246, А/245 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ НҮБ-ын санхүүжилтээс 0.5 сая төгрөгийг буцаан шилжүүлсэн боловч цалингийн зардлаар тайлагнасан, хүүхэд харах үйлчилгээний санхүүжилт 0.4 сая төгрөгийг цалингийн зардлаас олгож зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд 10.0 сая төгрөгийг дутуу шивсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Ажлаас чөлөөлөгдсөн 5 ажилтны дуусгалын тооцоог хийгээгүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-т "Ажил олгогч ажилтны ажлын байрыг хэвээр хадгалах тохиолдолд ажлыг нь түр, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон тохиолдолд бүрмөсөн хүлээн авна", 110 дугаар зүйлийн 110.3-т "Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.8-т "Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, дуусгавар болгох үед ажил олгогч нь ажилтантай ээлжийн амралтын тооцоог дараах байдлаар хийнэ" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн төлбөр болох 1.9 сая төгрөгийг төсвөөс төлсөн боловч буруутай этгээдээр нөхөн төлүүлээгүй нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний

хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.", Хөдөлмөрийн тухай хуулийн 132.1-т "Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ." гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 18 орлогын гүйлгээ, 53.7 сая төгрөгийн 3 зарлагын гүйлгээ, өр, авлага үүсгэсэн 23.3 сая төгрөгийн 25 шийдвэрийг мэдээлээгүй, 21.8 сая төгрөгийн 21 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"; Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол "Журам шинэчлэн батлах тухай"-ыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Бараа материалын үлдэгдэлд 2019 онд орлогод авсан 0.3 сая төгрөгийн хүнсний материал бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-т "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал

Илрүүлэлт: Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 6 дугаар зүйл "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автомашинд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар олгох арга хэмжээг 2022 онд багтаан зохион байгуулах"-ийн дагуу авто тээврийн хэрэгслийг тод өнгийн дэвсгэр бүхий улсын дугааргүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын эзэмшиж ашиглаж байгаа автотээврийн хэрэгслийг тод өнгийн дэвсгэр бүхий улсын дугаартай болгох ажлыг зохион байгуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 12 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	8	156.6	1	103.5	7	53.1	8	156.6	-	-	-	-

/сая төгрөгөөр/

Дүн	8	156.6	1	103.5	7	53.1	8	156.6	-	-	-	-
-----	---	-------	---	-------	---	------	---	-------	---	---	---	---

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	/сая төгрөгөөр/ Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	8	7.4	3	1.5	5	5.9	-	-	-	-	-	-
Дүн	8	7.4	3	1.5	5	5.9	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	/сая төгрөгөөр/ Үүнээс									
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	3	10.0			2	10.0			1	
Нийт дүн	3	10.0	-	-	2	10.0			1	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	1	-	-	-
	НИЙТ					1			